

УЛС ТӨР

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫНХАН
6000 ӨРХИЙГ ГЭРЭЛТЭЙ
БОЛГОНО ГЭВ


II нүүрт

УЛС ТӨР

Х.БАТТУЛГА: ГАНХУЯГ АА, ӨӨРИЙГӨӨ
БИШ ЮМ ГЭХЭД ЯДАЖ ЭЦГИЙНХЭЭ
НЭРИЙГ БОД

VI нүүрт

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР



Өдөр +30
Шөнө +14

Дугаарын 60 мөр

Уулын замд
“суурьшигчид”
хэрээс хэтэрлээ

Н.БАТЗАЯА

Их хотын завгүй нргэд зун цаг ирэхтэй зэрэгцэн гэр бүл, найз нөхөдтэйгөө хамт аялал зугаалганд явах нь их. Тэр бүү хэл зарим нэг нь холын замд гарч ядрахгүй гэж шалтгаанаар хогоос холгүйхэн голын зах бараадаж, сууцгаах болжээ. Яах вэ, агаар салхинд гарч болно. Тэртээ тэргүй өвөлжин бохир агаараар амьсгалдагаас хойш зуны гурван сардаа ч болтугай цэвэр агаар амьсгалж суухад буруудах зүйл үгүй. Гэхдээ зөв газраа суувал яасан юм бэ. Сүүлийн хэдэн жил Баянзүрхийн товчооны гүүрэн доогуур урсах Туул голыг бараадан агаар, салхинд гарах нргэдийн цуваа тасралтгүй үргэлжилсэн. Түүний ул мөр нь ч тодоос тод үлдсэн гэхэд болно. Туул гол илт татарч, ойр орчим нь хогонд даруулж буй. Жил бүр гадаадын болон дотоодын сайн дурын идэвхтнүүд Туул голыг аврах зорилгоор ойр орчмынх нь хогийг цэвэрлээд ч дийлдэхгүй байгаа нь бидний нүдэнд илхэн. Ус нь татарч, эрэг орчим нь хогонд дарагдсан болохоор ч тэр үү улс амьтан тийшээ чиглэх нь багасав.

Үргэлжлэл нь III нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

Г.ЧУЛУУНБААТАР САЙДАА
ГАДАГШАА “ЗАРАГДАЖ” БАЙГАА
БАГШ НАРАА АНХААРНА УУ



БОЛОВСРОЛ,
СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

Б.ӨНӨРТОГТОХ

УИХ-ын гишүүн асан Д.Энхбат саяхан твиттер хуудсандаа “Манай сайн багш нар Өвөрмонголд ажиллахаар явах нь олширчээ. Саяхан л хамт ажиллаж байсан зөвлөх багш маань явчихсан байна” хэмээн жиргэжээ. Түүний жиргээний дор энэ асуудал анхаарал татаж буйг олон ч хүмүүс онцолсон байх аж. Тэр ч байтугай тэтгэвэрт

гарсан багш нар Эрээний дунд сургуульд багшилж байгааг хүмүүс бичжээ. Өвөрмонголд ажиллаж, амьдрахаар явж байгаа багш нарын дийлэнх нь мэргэжлээрээ олон жил ажилласан туршлагатай хүмүүс байдаг гэнэ лээ. Тэр дундаа монгол судлал, Хөгжим бүжиг, СУИС-ийн багш нар хамгийн их гадагшаа очиж ажилладаг бөгөөд сарын 500.000 төгрөгийн цалингаас өөр орлогогүй сууж байснаас байр нь бэлэн, сардаа

500.000 юанийн тэтгэлэгээс гадна үндсэн цалингаа авч, сайхан орчинд ажиллахыг илүүд үздэг болсон нь энэ юм. Өвөрмонголд одоо Монголын түүхтэй холбоотой маш том музей баригдаж байгаа бөгөөд тэнд ажиллах монгол судлаачдыг ч манайхаас эрж хайх болсон гэнэ лээ. Асуудал ингээд дуусахгүй. Өвөрмонголыг зорьж ажиллаж байгаа хүмүүс дан ганц багш нар ч биш.

Үргэлжлэл нь III нүүрт

ОНЦЛОХ МЭДЭЭ



Гэрээ зургийг Г.АРГУУЖИН

Г.Шийлэгдамбад холбогдох хэргийн
шүүх хурал хойшиллоо

МАХН-ын генсек асан Г.Шийлэгдамба нарт холбогдох хэргийг шүүх хурал өчигдөр Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд товлөгдсөн байсан юм. Гэвч уг шүүх хуралдаанд Шшүүгдэгч Г.Шийлэгдамбын өмгөөлөгч Б.Энхзаяа, шүүгдэгч Г.Ганчимэгийн өмгөөлөгч Б.Баатарсайхан нар нь эрүүл мэндийн шатгааны улмаас шүүх хуралдаанд оролцоогүйгээ бөгөөд шүүхэд бичгээр мэдэгдэж, баримтаа хүсэлтийн хамт ирүүлсэн аж. Тиймээс шүүгдэгч нарыг өмгөөлүүлэх эрхээр хангах үүднээс шүүх хуралдааныг 10 хоногоор хойшлуулж, 2017 оны зургаадугаар сарын 22-ны өдрийн 09:00 цагт товложээ. Нийслэлийн Прокурорын газраас Г.Шийлэгдамбад Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2, Г.Ганчимэгт Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1, Э.Гантулга, О.Даваасүрэн нарт холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдсэн билээ.

АЯН ЗАМЫН ТЭМДЭГЛЭЛ

ЖЭК МА, АЛИБАБА ХОЁРООРОО
ГОЁХ ХАНЖОУЧУУД

Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ

Бээжингийн нисэх буудлаас хөөрөхийн өмнө хөтөч маань “Тэнгэрт диваажин, газарт Ханжоу” хэмээн Хөх мөрний эрэгт орших хотоор гайхуулаад амжсан. Яагаав өмнөх дугаарт онцолсон БНХАУ-ын дарга Си Зиньпиний ажиллаж амьдарч байсан хот шүү дээ. Алсын хараатай удирдагчийнхаа

буянаар Хан-Жоу хот эдүгээ дэлхийн анхаарлыг татахуйц эдийн засаг, соёл, боловсрол, тээвэр, санхүүгийн төв болтлоо өсч дэвжжээ. Газрын диваажин гэгдэх Ханжоу хот үзэсгэлэнтэйн дээр гудамж талбайгаа бидний ширхэгийг нь 2500 төгрөгөөр худалдаж авдаг сарнайгаар, тэгэхдээ бут бутгаар нь гоёсон байх юм.

Үргэлжлэл нь VI нүүрт

принцесса
Нури
ТАНСАГ
ЦЕЙЛОН ЦАЙ

GreenCity
Албан ёсны дистрибьютор

100%
принцесса
Нури
ВЫСОКОГОРНЫЙ

	ХААН банк			Худалгаа хөгжлийн банк								
		Авах	Зарах		Авах	Зарах		Авах	Зарах		Авах	Зарах
	АМ.ДОЛЛАР	2368.00	2389.00	ФУНТ	2980.00	3081.00	АМ.ДОЛЛАР	2368.00	2389.00	ФУНТ	2987.00	3069.00
	ЕВРО	2625.00	2699.00	РУБЛЬ	40.70	42.70	ЕВРО	2625.00	2698.00	РУБЛЬ	40.48	43.61
	ИЕН	21.41	21.79	ЮАНЬ	347.80	352.20	ИЕН	21.26	21.90	ЮАНЬ	348.00	351.40

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

БНОУХ-ийн төлөөлөгчид Монголд айлчиллаа

УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Цолмон өчигдөр Ашлэй Элизабет Вэйлэн тэргүүтэй Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэнгийн төлөөлөгчдийг хүлээн авч уулзжээ. Уулзалтын үеэр талууд хоёр орны парламентад мэргэжил, арга зүйн тусламцаа үзүүлдэг бүтцийн талаар мэдээлэл солилцсон байна. Мөн “УИХ-ын Тамгын газрын үйл ажиллагааг дэмжих нь АНУ-ын хороодын тогтолцоо” сэдэвт сургалтын талаар харилцан ярилцжээ. Уулзалтад Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэнгийн улс төрийн хөгжлийн хөтөлбөрийн захирал Жессика Кинган, сургагч багш Брэд Смит болон тус хүрээлэнгийн улс төрийн хөтөлбөрийн мэргэжилтэн Д.Дариймаа нар оролцсон аж. Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн нь 1983 оны дөрөвдүгээр сард үүсгэн байгуулагдсан бөгөөд ашгийн бус, нам бус байгууллага юм. Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн нь улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллагыг чадавхжуулж, нээлттэй сонгууль, ардчилсан засаглал болон эрхзүйт ёс хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж, дэлхийн өнцөг булан бүрт эрх чөлөө, ардчиллыг хөгжүүлэх зорилготой юм байна. Тус байгууллага 1992 оноос Монгол Улстай хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлж иржээ.



Гэрэл зургийн Г.АРГУУЖИН



Н.БАТЗАЯА

Эрчим хүчний салбарын нээлттэй хаалганы өдөрлөгийн нээлт өчигдөр боллоо. Өдөрлөгт эрчим хүчний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 30 орчим компани оролцож, иргэдэд ажлаа тайлагнав. Энэхүү үйл ажиллагааг нээж, Эрчим хүчний сайд П.Ганхүү “Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн системийн өсөн нэмэгдэж буй хэрэглээг дотоодын үйлдвэрлэлээр хангах, импортын эрчим хүчний хэмжээг бууруулах зорилгоор одоо үйл ажиллагаа явуулж буй

Эрдэнэтийн дулааны цахилгаан станцыг 35 МВт-аар, Дарханы дулааны цахилгаан станцыг 35 МВт-аар, Чойбалсангийн дулааны цахилгаан станцыг 50 МВт-аар, Дулааны гуравдугаар цахилгаан станцыг 250 МВт-аар тус тус өргөтгөх шийдвэрийг гаргаад байна. Энэ шийдвэрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллаж байгаа бөгөөд Эрдэнэт, Дарханы дулааны цахилгаан станцын өргөтгөлийн ажлыг хийх гүйцэтгэгчийг шалгаруулан гэрээ байгууллаа. Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Ажлын байрыг нэмэгдүүлэх зөвлөмжийг Засгийн газарт хүргүүлнэ

УИХ-ын Өргөдлийн байнгын хорооноос өчигдөр хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажлын байрыг нэмэгдүүлэх асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг зохион байгууллаа. Хэлэлцүүлгийг нээж, Өргөдлийн байнгын хорооны дарга Д.Сарангэрэл “Хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлэх асуудлаар манай байнгын хороо гурав дахь удаагаа хэлэлцүүлэг зохион байгуулж байна. Ажлын байр нийгэмд хамгийн том тулгамдсан асуудал болсон. Тиймээс өмнө нь хоёр удаа хэлэлцүүлэг хийж, хэлэлцүүлгээс арваад зөвлөмж гаргаснаас таван асуудал УИХ-аар баталсан Эдийн засгийг сэргээх төлөвлөгөөнд тусгагдсан байгаа.

Тухайлбал, ажлын байрыг тогтвортой хадгалж байгаа аж ахуйн нэгжийг төрийн бодлогоор дэмжих, иргэдийг гадаад улсад тодорхой хугацаагаар ажиллуулах чиглэлээр төрөөс тодорхой арга хэмжээ авах, төрөөс бизнес эрхлэгчдэд олгож байгаа тусгай зөвшөөрлийн тоо зэрэг асуудал Эдийн засгийг сэргээх төлөвлөгөөнд тусгагдаад хэрэгжиж эхэлж байна” гэв. Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны дэд ерөнхийлөгч С.Эрдэнэбат ажлын байр нэмэгдүүлэх ажлыг ганцхан Хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд тохолгүй, бүх яамд дэргэдээ салбар зөвлөл ажиллуулж, ажлын байр шинээр бий болгоход анхаарч ажиллах, гадаад улсуудад гурван жилээс дээш хугацаагаар ажиллах залуусыг гэр бүлтэй нь явуулах зэрэг асуудлыг зөвлөмжид тусгах хэрэгтэй гэх саналыг хэлжээ. Хэлэлцүүлэгт оролцогчдын саналыг тусган зөвлөмж гаргаж, зөвлөмжийг Засгийн газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад хүргүүлэх юм байна.

УИХ дахь намын бүлгүүд хуралдсангүй

Хуваарь ёсоор УИХ дахь намын бүлгүүд өчигдөр Төрийн ордонд хуралдах ёстой байсан юм. Гэвч намын бүлгүүд хуралдсангүй. Намын бүлгүүд тогтсон цагтаа хуралдахгүй байгаа нь Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотой хэмээн зарим эх сурвалжууд үзэж байгаа аж. Учир нь Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгаа орон даяар үргэлжилж буй. Үүнтэй холбогдуулан гишүүд өөр өөрсдийн тойрогт ажиллаж байгаа билээ. Ямартай ч эрхэм гишүүд Ерөнхийлөгчийн сонгуульд анхаарлаа хандуулан тун ч завгүй яваа бололтой.

нэмэгдүүлэх, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологийг нэвтрүүлэх зорилтын хүрээнд Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт 10 МВт-ын суурилагдсан хүчин чадалтай нарны станцыг 2017 оны нэгдүгээр сард ашиглалтад орууллаа. Мөн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт 50 МВт-ын салхин станцын ажил өрнөж байгаа бөгөөд 2017 онд ашиглалтад оруулах зорилгын хүрээнд одоогийн байдлаар угсралтын ажил 60 гаруй хувьтай үргэлжилж байна” гэв. Мөн сүүлийн үед дэлхий нийтээр агаарын бохирдлыг бууруулахад анхаарч ажиллаж буй. Тэгвэл эрчим хүчний салбарынхан агаарын бохирдлыг бууруулж, ард иргэдийн ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлж, өрхийн зардлыг бууруулах бодлогын хүрээнд Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхийн шөнийн цахилгааны төлбөрийг

100 хувь хөнгөлөх шийдвэрийг Засгийн газраас гаргасан юм. Хөнгөлөлтөд нийслэлийн гэр хорооллын хоёр тарифт тоолууртай 110 мянга гаруй хэрэглэгч хамрагдсанаар нийт 3.363.7 сая төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэн гэдгийг салбарын сайд онцлов. Засгийн газраас томоохон цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцуудыг өргөтгөх, шинэчлэх, шинээр барих шийдвэр гаргасан билээ. Үүнтэй холбогдуулан Оюутолгой-Цагаансуваргийн 220 кВ-ын хоёр хэлхээт 159.5 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих ажил явагдаж байгаа гэнэ. Одоогоор барилга угсралтын ажил 90 хувьтай байгаа аж. Мөн Багануур-Чойрын 220 кВ-ын 178 км ЦДАШ, Багануур дэд станцын өргөтгөл, Улаанбаатар-Мандагловийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барих төслийн бэлтгэл ажил гээд их бүтээн байгуулалт

Гадаадад оршин суугаа иргэдийн 66.8 хувь нь саналаа өгчээ

Орон даяар Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгаа явагдаж байгаа ч хуулийн дагуу гадаадад суугаа иргэд энэ сарын 10, 11-нд саналаа өгсөн билээ. Тэгвэл гадаадад суугаа Монгол Улсын иргэдээс Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн санал авах ажиллагааг амжилттай зохион байгуулсан талаар өчигдөр Төв комиссоос мэдээлэл хийлээ. Энэ удаагийн сонгуулиар

гадаадад суугаа Монгол Улсын иргэдээс санал авах ажлыг зохион байгуулахаар 33 улсад 45 салбар комисс байгуулагдан ажилласан байна. Гадаадад суугаа сонгогчдын саналыг Сонгуулийн тухай хуулийн дагуу УИХ-аас тогтоосон өдрүүдэд тухайн орон нутгийн цагаар 07:00 цагаас 22:00 цагийн хооронд авах ёстой учир хамгийн эхэнд Австрали Улсын Канберра хот дахь салбар комисс санал хураах ажиллагаагаа

өрнөж буйг салбарынхан онцолж байлаа. Эрчим хүчний салбар Монгол Улсын хөгжил, цэцэглэлтийн төлөө багагүй хувь нэмрээ оруулжээ. Тухайлбал, гэрэл цахилгаангүй болон хүчдэлийн уналттай байсан нийслэлийн захын гэр хорооллын нийт 22 байршлын 1562 айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангаж ажиллажээ. Ард иргэдийн зүгээс олон жилийн турш хүсэлт болгон тавьсан энэ ажлыг үргэлжлүүлж, 2017 онд нэмж 6000 айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангахаар төлөвлөн нийтдээ 43 багц тендерийг зарласан байна. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд гэр хорооллын бүсэд одоо үйл ажиллагаа явуулж буй нийт 123 халаалтын зуухыг буулгаж, хэрэглэгчдийг төвлөрсөндүлаан хангамжид холбож эхэлсэн гэнэ. Уг ажлын хүрээнд эхний ээлжинд Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй зарим халаалтын зуухыг татан буулгаж, тусуурын зуухнаас халаалтаа авч байсан сургууль, цэцэрлэг, эмнэлгийг төвлөрсөн дулаан хангамжийн системд холбох ажлыг хийж эхэлжээ. Мөн Хөвсгөл нуурын жуулчны баазуудыг төвлөрсөн эрчим хүчээр хангах хүрээнд Хатгал тосгоноос Тойлогт нуур хүртэлх 40 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барих ажлыг хийж буй гэх мэтчилэн Эрчим хүчний салбарынхан энэ өдөр иргэддээ хэлэх үг, хийсэн ажилтай байсан юм. Өдөрлөгийн үеэр хүрэлцэн ирсэн иргэдэд төсөл хөтөлбөр болон цахилгаан халаагуур тоног төхөөрөмж танилцуулж, эрчим хүчний үнэ тариф, эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөв. Мөн цахилгаан, дулааны техникийн нөхцөл, эрчим хүчний барилга угсралтын тусгай зөвшөөрөл, эрчим хүчний салбарт мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх талаар мэдээлэл өгч, цогц үйлчилгээ үзүүлээ. Тус өдөрлөг өнөөдөр Сүхбаатарын талбайд үргэлжилнэ.

О.Магнай: Х.Баттулга оффшорт данстай гэх гүтгэлгийн чанартай мэдээллийг шалгуулна

МАН-ын Бага хурлын гишүүн Ч.Ганхуяг энэ сарын 09-нд Ерөнхийлөгчийн сонгуульд Ардчилсан намаас нэр дэвшигч Х.Баттулгыг оффшор бүсэд 1.1 тэрбум ам.долларын өөрийн хөрөнгөтэй хэмээн бичлэг хийж, олон нийтэд цацсан билээ. Тэгвэл Ардчилсан намаас түүний энэхүү мэдээлэл нь сонгуулийн үеэр нэр дэвшигчийг нэр хүндийг гутаах гэсэн худал мэдээлэл хэмээн цагдаагийн байгууллагаар шалгуулахаар болсон байна. АН-ын Нарийн бичгийн дарга О.Магнай, хуульч Р.Булгамаа нар өчигдөр Сүхбаатар дүүргийн цагдаагийн газарт хандлаа. Энэ үеэр АН-ын Нарийн бичгийн дарга О.Магнай “Өнгөрсөн долоо хоногт фэйсбүүк, твиттерээр манай нэр дэвшигч Х.Баттулгатай холбоотой гүтгэлэгт явсан. МАН-ын гишүүн Ч.Ганхуяг гэж хүн цагдаагийн байгууллагад хандаж байна. Энэ асуудлаар нэр дэвшигчтэйгээ би ярилцсан. Тэрбээр “Надад




Гэрэл зургийн Г.АРГУУЖИН

оффшор дансанд болон компани байхгүй. Харин тэр Ч.Ганхуяг гэдэг нөхөрт хандаж хэлэхэд “Хэрвээ оффшор бүст миний 1.1 тэрбум ам.долларын хөрөнгө байвал, тэр мөнгийг өөрөө аварай” гэж хэлсэн. Манай нэр дэвшигчийг сүүлийн жил гаруйн хугацаанд олон хэрэгт янз бүрийн байдлаар холбох гэж оролдож байгааг та бүхэн мэдэж байгаа. Тиймээс оффшор бүсэд ийм их

хэмжээний мөнгөтэй байсан бол аль хэдийнэ ил гаргачих байсан биз. Уг асуудлыг цагдаагийн байгууллагынхан түргэн шуурхай хуулийн хүрээнд шалгах байх гэж найдаж байна” гэв. Харин хуульч Р.Булгамаа “Иргэн Ч.Ганхуягийн яриад байгаа энэ асуудалд нь ямар ч нотлох баримт байхгүй. Нэр дэвшигчийн хувьд оффшор бүсэд ямар нэгэн данс, компани байхгүй” гэлээ.

ҮЗЭЛ БОДОЛ

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ



УИХ-ын гишүүн
З.Нарантуяа

Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

ҮЗЭЛ БОДОЛ

Г.ЧУЛУУНБААТАР САЙДАА ГАДАГШАА “ЗАРАГДАЖ” БАЙГАА БАГШ НАРАА АНХААРНА УУ

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Амралтын хугацаандаа СУИС-ийн оюутнууд ч тус улсыг зорьж ажил хийдэг бол, хаврын цагт туслах малчнаар өмнөд хөршийг зорих иргэд ч нэмэгджээ. Сардаа нэг сая төгрөгийн цалинтай, бас буцахдаа хувцас авах мөнгөтэй ирдэг ч үнэн хэрэгтээ тэд “боолын хөдөлмөр” эрхэлж байгаад ирдгийг нэгэн танил маань ярьж байсан юм. Ажилгүйгэртээ хэвтэж байснаас амьдралаа залгуулахын тулд хилийн дээс алхаж буй тэднийг буруутгах гэсэнгүй. Гэвч боловсролын салбараас давалгайлсан энэ хандлага эрүүл мэндийн салбар, цаашлаад бусад салбарт нөлөөлвөл хэрхэх билээ. Дотооддоо ур чадвараа 500 мянган төгрөгөөр үнэлүүлж, амьдрах гэж арга ядаж сууснаас гадагшаа мэргэжлээрээ ажиллахаар чадвартай эмч нар маань хилийн дээс алхчихвал бид хэрхэх вэ. Судас олж чадахгүй эмч нар, үгээ зөв бичиж чадахгүй багш нар л Монголд минь үлдэж хоцрох вий гэсэн эмзэглэл байгааг нуух юун. Монгол Улсын ирээдүйн ажиллах хүчнийг бэлтгэх учиртай чадалтай багш нараа үнэлж чадахгүй байгаа учраас нийм асуудал үүсч байгаа хэрэг. Хийснийг нь үнэлж чаддаг газарт ажил хийхэд ч урамтай байдаг хойно судалгаа шинжилгээг чинь үнэлье гээд урьж байхад зугтах тэнэг хүн байхгүй болов уу. Тиймээс эдгээр багш нарыг буруутгах гэсэнгүй. Бид цөөхөн монголчууд. Гэвч монгол хүний оюуны ухааны цараа, сэтгэх чадвар дэлхийд хүлээн зөвшөөрөгддөг, бүр дээгүүрт бичигдэж эхэлсэн. Дэлхий дахин чадалтай эрдэмтэн, чадварлаг уран бүтээлч, спорт, урлагийн гоц авьяастануудаар “чангаж” байгаа. Тэр ч утгаараа аль үндэстэн байхаас үл шалтгаалж өндөр үнээр худалдаж авдаг, өөрийн улсын иргэншлийг асар их мөнгөөр санал болгодог болчихож. Түүний тархийг өөрийн улсын хөгжил дэвшлийн төлөө ашиглахын тулд тэд хөрөнгө мөнгө харамлахгүй байгаа нь энэ. Гэтэл монголчууд бид дотооддоо өнөөх л эх оронч гэсэн тамын тогооны үлгэрээ ярьсаар суутал хамаг чадалтай залуус маань гадагшаа хар ажилчнаар гарч, мэдлэг боловсролтой нь сарын цалингийн төлөө эх орноосоо нүүр буруулахад хүрч байх жишээтэй. Үүний жишээ ч Монголд цөөнгүй бий. Монголын нэг эрдэмтэн шинэ нээлт хийхэд түүнийг нь төр засаг дэмжээгүй байхад гадныхан олж харчихаад худалдаж авах санал тавьж байсан тохиолдол маш олон бий. Спортын томоохон амжилт гаргасан тамирчид маань эхнээсээ гадны улсын нэр дээрээс барилдаж, иргэншилээ сольдог боллоо. Анхлан Олимпын хошой хүрэл медальт, дэлхийн аварга,

гавьяат тамирчин Д.Мөнхбаярыг Герман улсын иргэн болоход олон хүн гайхширан хүлээж авч байлаа. Муулах хүн ч бишгүй олон байсан. Тэгвэл энэ асуудал одоо байдаг л үзэгдэл мэт болжээ. Казахстан, Япон зэрэг улс орнуудын нэр дээрээс манай тамирчид барилдаж, бас уралдаж байна. Тэр ч байтугай хүндийн өргөлтийн залуухан тамирчин Э.Анхцэцэгт тэрбум ам.доллар санал болгож, өөрийн улсын нэр дээрээс тэмцээнд оролцохыг санал болгосон тухай мэдээлэл хэвлэлийн шарласан хуудаснаа тодхон байх аж. Гэтэл энэ мэт мэдээг байх ёстой зүйл мэт хардаг, бараг л баярлах шахуу хүлээж авч хэрхэвч боломгүй байлтай. Улс нь анхаарахгүй байхад амьдралаа бодоод явсан нь дээр хэмээн өмгөөлж болох ч үндэсний аюулгүй байдал үүний цаана яригдаж байгааг анхаарахгүй өнгөрч боломгүй юм. Дахин хэлэхэд бид цөөхөн монголчууд. Долоон тэрбум хүнтэй бөмбөрцөг дэлхийн маш жижигхэн эд эс. Хэзээ ч мөхөж мэдэх цөөхөн хүн амтай “жижигхэн” улс. Тиймээс төр харж үзсэнгүй хэмээн гадагшаа явдаг, сайхан амьдралын төлөө иргэншилээ солих байдлаар нэг иргэнээ алдсаар байвал юу болох вэ. Үндэстэн мөхөх эхлэлийг л тавьж байна гэхэд дэгсдүүлсэн болохгүй. Монгол хүний оюун ухааныг Монголдоо бид зөвөөр ашиглах хэрэгтэй байна. Энэ улсын хэтийн хөгжил, ирээдүйн төлөө салбар бүртээ анхаарахаас өөр аргагүй. Тэр тусмаа боловсролын салбарыг үл тоож боломгүй байлтай. Багшийн үнэлэмжийг дээшлүүлж, судалгаа шинжилгээг нь бодитоор дэмждэг болохсон. Их дээд сургуулийн багш нар лекцээ ном болгож хэвлүүлснээрээ биш улсын хөгжлийн төлөө хийсэн бүтээсэн том ажил, эрдэм шинжилгээний гайхалтай бүтээлээрээ өрсөлддөг, түүнийгээ үнэлүүлдэг болсон цагт сая л монгол хүнээ дэмжиж байна гэж хэлэх биз. Үүнийг улстөржүүлэх шалтгаан байхгүй ч засаглалын тогтолцоо тэр хэрээр буруутай. Төр хэрвээ салбар салбарын бодлогоо зөв тодорхойлдог бол, улс төрийн намуудын нөлөө салбар бүрт ордоггүй бол тэд бүгд жамаараа явсаар хөгжих учиртай юм. Даанч тийм боломж алга. Их дээд сургууль байтугай сургуулийн цэвэрлэгчийг хүртэл намаар ялгаж ажилд авдаг цаг үед мөнгө өгсөнд нь тархин дахь мэдлэгээ худалдахаас өөр яалтай. Чадалтайг нь гадныхан шүүрдэж авсаар байгаа учраас чадалгүй нь тунаж үлдэнэ. Чадваргүй багшийн гараас арван үг ч зөв бичиж чадахгүй боловсон хүчин бэлтгэгдэж гарна. Тэд хувь, хувьсгалын ажил хийж, тэр ч байтугай төрд орж суучихаад

...Үүнийг улстөржүүлэх шалтгаан байхгүй ч засаглалын тогтолцоо тэр хэрээр буруутай. Төр хэрвээ салбар салбарын бодлогоо зөв тодорхойлдог бол, улс төрийн намуудын нөлөө салбар бүрт ордоггүй бол тэд бүгд жамаараа явсаар хөгжих учиртай юм...

төрийн бодлого, хуулийг самарч буй учраас энэ улсын хөгжил урагшаа биш хойшоо яваад байгаа юм. Эмнэлгийн салбарын хөгжил, хүнд суртлын тухай бид хангалттай бичсэн. Одоо харин Боловсролын салбарын талаар тууштай дугарах цаг нь болжээ. Шинэчлэл, өөрчлөлт ярихаар ганц сайдыг халаад л цэгцрэх асуудал биш. Боловсролын салбарт яг одоо эрс өөрчлөлт хэрэгтэй байна. Багшийн үнэлэмжийг дээшлүүлэх нь юу юунаас илүүтэй анхаарал татах сэдэв болоод байна. Шалгалтын ганц материал задрахаас ч ноцтой асуудал яригдаж байгааг сануулах нь илүүц биз. Их дээд сургуулийн элсэлтийн шалгалтын үеэр эзэнгүй байсан боловсролын салбар өнгөрөгч долоо хоногт арайхийн эзэнтэй болов. Тэр ч байтугай мундаг академичийг сайдаар томилж “гийгүүлсэн” дуулдана. Тэгвэл Г.Чулуунбаатар таны ажил багшийг үнэлэхээс эхлэх учиртай шүү. Хэдхэн халтар төгрөгийн төлөө харьд ажиллах сонголт хийж байгаа чадалтай боловсон хүчнээ буцааж авчрахаас эхлэх ёстойг сануулчихъя. ЕБС цаашлаад Их дээд сургуулийн ажиллах хүчинг чадваржуулах, тэдний

хөдөлмөрийг шударгаар үнэлж гэмээнэ бодит ажил, шинэчлэлт болох учиртай юм. Түүнээс биш нэг хүнийг халж солилоо гээд өөрчлөлт хийгдэхгүй гэдгийг эрхэм сайдтан таньд хэрэг болгон дуулгая. Шинэхэн дээрээ сонихон гэгчээр энэ салбарт өөрчлөлт хийнэ гэх итгэл, хүлээлт байгааг бүү мартаарай. Эс тэгвээс эзний суудал ээлжтэй, хааны суудал халаатай гэдгийг мартаузай.

Дугаарын 60 мөр

Уулын замд “суурьшигчид” хэрээс хэтэрлээ

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Харин энэхүү урт гэгч цуваа Богд уулын замыг чиглэсэн бололтой. Тодруулбал, Нисэх-Яармагаас Богд уулын араар хөвөөлөн Баянзүрхийн товчоо хүртэл үргэлжилдэг 17.1 км авто замын хажуугаар урсах Туул голын хөндийг бараадан “суурьшигчааж” байна. Их цувааг дагасан майхан сав, машин тэрэг ч олон. Түүнээс гадна хүн ихтэй газар байрших гэсэн “шорлог”, “хорхог”, “ундаа” зэрэг жижиглэн бүтээгдэхүүн зардаг иргэд ч салахаа болилоо. Мэдээж хүн их цугларсан газрын ойр орчим бохирдох нь тодорхой. Түүнээс гадна зориулалтын бус газар хэт олноороо очиж байрласнаас болж осол, аваар ч дийлдэхээ больсон байх юм. Уг нь Богд уулын арын замыг хотын төвийн түгжрэлийг 30-аас багагүй хувиар бууруулах, иргэдийн цаг, мөнгийг ихээхэн хэмнэх, аялал жуулчлалын улиралд зочид гийчдийг түгжрэлгүй зорчуулах зорилготойгоор тавьсан юм билээ. Дээрээс нь уулын зам учраас огцом эргэлт ихтэй. Мөн анхнаасаа зам дагуу үйлчилгээний газар төлөвлөөгүй болохоор нарийнхан замтай. Туул голд амрахаар ирсэн иргэдэд зориулсан машины зогсоол ч байхгүй. Замдаа шорлог, ундаа авах гэсэн иргэд замын хажуу руу машинаа оруулж тавьснаас болж зам тээврийн осол гарах нэг шалтгаан болжээ. Арга ч үгүй биз. Давчуухан зайнд хүмүүс амарч, худалдаа үйлчилгээ явагдаж байна шүү дээ. Аялал, зугаалганд явж болно, гэхдээ өөрсдийгөө эрсдэлд оруулах шаардлага байна уу. Заавал амь насаа эрсдэлд оруулан зориулалтын бус газар очих ч хэрэг алга, Монголд амрах газар мундсан биш. Нөгөөтэйгүүр хууль, хяналтын байгууллагынхан ч тэнд алга. Хэтрүүлэгтэй ярьсан хүнд өглөөгүүр тав алхаад л машин зогсоож харагддаг замын цагдаа нарын бараа ч алга байна билээ. Бурхангүй газрын бумба галзуурна гэгчээр уулын замд чимээгүйхэн “суурьшигчид” хэрээс хэтэргээ, хууль хяналтынхан минь. Осол, аваарь гарахаар нь л дуудлагын дагуу очдог улиг болсон зуршлаас салж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авбал дээрсэн. Тэртээ тэргүй түгжрэл ихтэй хотын төвд чинь түгжрэлийг улам түгждэг олон цагдаагийн хэрэг ч алга. Заримыг нь ч болтугай Богд уулын арын замд ажиллуулаач. Тэгэхгүй бол тэр хавиар урсан өнгөрөх Туул голын сав газар Баянзүрхийн товчооны түүхийг давтах нь. Түүнээс гадна өдөр бүр нийслэлийн Замын цагдаагийн албанд ирэх осол, аварайн дуудлагын тоог улам л нэмэгдүүлэх нь байна шүү. Ер нь аливаа зүйлийг зориулалтынх нь дагуу л ашиглавал сайнсан.

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

Сонгон шалгаруулалтын нэр: Байгууллагад нэвтрэх хяналт, хаалга удирдлагын систем худалдан авах
Сонгон шалгаруулалтын дугаар: №2017-16

МҮОНРТ-ийн

- 37ш металл хаалга /нийт 121,2м2/,
- 62ш соронзон цоож, 1000ш нэвтрэгч карт,
- Карт уншигч, удирдлагын контроллер бүртгэлийн программ
- Төв хаалга:

Турникен /дан мотортой/	2ш
Турникен /давхар мотортой/	2ш
Карт уншигч	4ш
Удирдлагын контроллер	2ш

Ачааны шилэн хаалт, хаалга 2ш бараа ажил үйлчилгээг худалдан авахаар сонгон шалгаруулах тендер зарлаж байгаа тул оролцох эрх бүхий аж ахуйн нэгж, албан байгууллагыг үнийн саналаа ирүүлэхийг урьж байна.

Эрх бүхий этгээд нь сонгон шалгаруулалтын материалд дараах зүйлсийг заавал тусгасан байна.

Үүнд:

Тавигдах техникийн шаардлага:

- Эрчим хүчний хэмнэлттэй байх
- Засвар үйлчилгээ хийхэд тохиромжтой байх
- Өнгө үзэмж сайтай байх
- Хүчдэлийн төвшин тодорхой байх
- Хэрвээ бууруулагчтай бол түүнийг холбож баталгаа гаргах
- Цахилгаан тасарсан тохиолдолд батерейгаар ажиллах
- Батарейны ажиллах хугацаа нь баталгаатай байх
- Цахилгаан тэжээлийг татахад шаардлагатай монтажийн ажлыг хийж гүйцэтгэхдээ МҮОНРТ-ийн цахилгааны хэсгийн инженер техникийн ажилчдаас
- Хаалганы цахилгаан цоож тус бүрийг цахилгааны тэжээлд холбосны дараа дугаарлаж , тэмдэг тэмдэглэгээ хийх
- Нийт цахилгаан цоож болон хаалганы мэдээллийг нэгтгэн техникийн паспортжуулна
- Бүртгэлийн программ нь хэрэглээний хамгийн энгийн, ойлгомжтой, бусад системтэй холбогдох тал дээр уян байх.

Эрх бүхий этгээд нь сонгон шалгаруулалтын материалд дараах зүйлсийг заавал тусгасан байна. **Үүнд:**

- Компани, аж ахуйн нэгжийн танилцуулга, туршлага
- Компани, аж ахуйн нэгж нь энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх улсын бүртгэлийн гэрчилгээтэй байх /нотариатаар баталгаажуулсан/
- Төлбөрийн хөнгөлөлт –Үүнийн хөнгөлөлт
- Бараа ажил үйлчилгээ солилцооны /бартер/ хэлбэрээр байж болно.
- Үүнийн санал ирүүлэх /НӨАТ, гаалийн болон бусад бүх зардал шингэсэн байх/

МҮОНРТ-ээс зөвхөн тухайн сонгон шалгаруулалтад шалгарсан ААН, иргэн, хуулийн этгээдэд эргэн хариу мэдэгдэнэ.

Холбогдох материалаа битүүмжлэн 2017 оны 6 дүгээр сарын 19-ны өдрийн 17 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлнэ үү.

Хаяг Баянгол дүүрэг Хувьсгалын зам-3
МҮОНРТ-ийн байр 2 давхар нягтлан бологчдын өрөө
Т.Анхтуяа Утас: 93136030
М.Баярхүү Утас: 99027997

УЛС ТӨР

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ-2017

Х.БАТТУЛГА: ГАНХУЯГ АА, ӨӨРИЙГӨӨ БИШ
ЮМ ГЭХЭД ЯДАЖ ЭЦГИЙНХЭЭ НЭРИЙГ БОД

Н.ПУНЦАГБОЛД

Ерөнхийлөгчийн сонгуульд АН-аас нэр дэвшигч Х.Баттулгын иргэд, сонгогчидтойгоо хийх уулзалт үргэлжилсээр байна. Тэрбээр өчигдөр өглөө Өндөр гэгээн Занабазарын нутаг Өвөрхангай аймгийн иргэдтэй уулзлаа. Уулзалтад нэр дэвшигчээс гадна АН-ын дарга, УИХ-ын гишүүн С.Эрдэнэ, УИХ-ын дарга асан З.Энхболд, Өвөрхангай аймгийн АН-ын дарга Л.Энхбат, Мэргэжлийн сүмо бөхийн 68 дахь их аварга Асашёрюү Д.Дагвадорж нарын албаны болон олны танил эрхмүүд оролцлоо. Уулзалтын эхэнд Өвөрхангай аймгийн АН-ын дарга Л.Энхбат үг хэлж, өврийн сайхан хангай нутгийнхаа иргэд, сонгогчдод эх оронч нэр дэвшигчийг дэмжихийг уриалав. Энэ үеэр Х.Баттулга “Өврийн сайхан хангай нутагт ирсэн даруйдаа аймгийн Хөгжимт драмын театрт иргэд, сонгогчидтой уулзсан юм. Энэ үеэр хэлсэн үгэндээ “Монголчууд бид түүхэнд үлдэх чухал сонголтын өмнө нүүр тулж ирээд байна. 2007 оноос хойш Тавантолгойд санаархсан нүүрсчин намын бүлэглэл намайг элдвээр харлуулж, эцэстээ оффшорчин гэж гүтгэж гүжирдэж байна. Үүнээс өмнө төмөр замын мөнгийг идэж уусан гэж элдвээр гүжирдсэн. Чулуу шидсэн болгон руу буцааж шидээд байвал юу болох вэ. Худал хуурмаг, гүжир гүтгэлэг болгонд хариу бариад байх цаг хугацаа, зав зай ч алга. Аяндаа цаг хугацаа харуулна биз. Гэхдээ өнөөдөр энэ индрээс ганцхан зүйлийн



тухай онцлох гэсэн юм. Сонгууль ойртох тусам утга учиргүй худал мэдээлэл цахим орчин, мэдээллийн сайтуудаар цацагдаж байна. Та бүхэн таних байх. Чулууны Ганхуяг гэх залуу саяхан намайг гадаад дансанд мөнгө нуусан, оффшор бүст бүртгэлтэй гэхчлэн ярьж, бичиж байна. Би 1990-ээд оны эхэн үед энэ хүүгийн аавтай ганзагын наймаанд хамт явдаг байсан. Тэр үед Ганхуяг жаахан бор хүү байсан. Угтаа, ганзаганд явна гэдэг тухайн үед ёстой л нөгөө Аса аваргын хэлдгээр алаан байхгүй юу. Тэр үед бид очсон гараа буудлын нэг өрөөнд арав, хориулаа байрладаг байв. Хөөгдөнө, туугдана, бараагаа хамт зөөнө. Шатахдаа хамт шатна, хоолоо хувааж иднэ. Ийнхүү яг л нэг

гэр бүл шиг замналыг хамт туулж байсан Чулуун гэж хүн байсан юм. Ганхуягт хандаж хэлэхэд өөрийгөө биш юм гэхэд ядаж эцгийнхээ нэрийг бодооч ээ. Цагтаа би аавд чинь тус болж л явлаа. Банк, санхүүгийн салбарт ажилладаг тийм л боловсролтой хүн юм бол нэгдүгээрт наад гүтгэлгээ зогсоо. Хоёрдугаарт, өөрийг чинь гар хөлөө болгоод байгаа тэр ах нар нь өнөөх гучин хэдэн оффшорчдын бараг 90 хувь нь байгаа юм. Бид Хэнтий аймагт сонгуулийн сурталчилгааны нээлтээ хийхдээ АТОЗ буюу Ард түмний онц зөвлөл гэх байгууллагатай “оффшортой тэмцэнэ, оффшорт байгаа улстөрчдийн мөнгийг татаж авчирна” хэмээн санамж бичигт гарын үсэг зурсан. Үүнд



эмзэглэсэн үү яасан, хариу болгож ийнхүү гүжирдэж байгаа бололтой. Би үнэхээр оффшор данстай байсан бол ингээд Ерөнхийлөгчид нэр дэвшээд явж байх уу” гэсэн юм. УИХ-ын дарга асан З.Энхболд төрөлх нутгийнхаа иргэдэд хандаж үг хэлж, Х.Баттулга нэр дэвшигчийн талаар өөрийнхөө бодлыг нутгийн олондоо дуулгав. Тэрбээр “Намайг үргэлж дэмжиж байсан өвөрхангайчууддаа баярлаж явдаг шүү. Гурван нэр дэвшигчийг гурвууланг нь сайн, Ерөнхийлөгч болж чадна гэж намууд нь итгэл хүлээлгэсэн байх. Энэ дундаас өнгөрсөн нэг жилийн хугацаанд болсон алдаа завхралыг засаад явж чадах хүн бол Халтмаагийн Баттулга. Яагаад вэ гэдгийг хэдэн жишээгээр тайлбарлая. Яг жилийн өмнө зургадугаар сард УИХ-ын сонгууль болсон, АН ялагдсан. АН алдаа дутагдалдаа дүгнэлт хийгээд, гишүүдээрээ асуудлаа шийдүүлдэг болж, Баттулга нэр дэвшигчийг хүртэл нийт гишүүдээсээ сонгосон. Нөгөө хоёр нэр дэвшигчийг бол цөөн хэдхэн дарга нараараа шийддэг хуучин аргаар тодруулсан юм билээ. Бид УИХ-ын сонгуульд яагаад ялагдчихав гээд дүгнэлт хийгээд явж байтал сахиан тодорхой болсон. Монгол Улсын төрийн албыг 60 тэрбумаар зарсан нь ил болсон. Намайг УИХ-ын дарга байхад сургуулийн захирал багш ажилд авахдаа сая төгрөгийн авлига аваад шоронд суусан. Гэтэл 22 мянган төрийн албан хаагчийг хууль бусаар халаад, албан тушаалыг нь зараад, тэр

мөнгөө сонгуульд зарцуулсан нам төрийг удирдаад л явж байна” гэв.

Х.Баттулга цэрэг дайчдад эх орны бүтээн байгуулалтад оролцох боломжийг танилцуулав

Нэр тэр дэвшигч Х.Баттулга Өвөрхангай аймаг дахь Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн бие бүрэлдэхүүн, офицер ахлагч, цэрэг дайчидтай уулзаж мөрийн хөтөлбөрөө танилцуулсан юм. Биднийг 256 дугаар ангийн захирагч, хурандаа н.Галбадрах, Штабын дарга, дэд хурандаа н.Дэлгэрсайхан нар угтан авч бие бүрэлдэхүүнтэй танилцууллаа.



Нэр дэвшигч Х.Баттулгын “Хүчирхэг Монголын төлөө” мөрийн хөтөлбөр танилцуулах уулзалтад аймгийн Ардчилсан намын дарга Л.Энхбат, УИХ-ын гишүүн асан Ц.Оюунгэрэл, Мэргэжлийн сүмогийн их аварга Асашёрюү Д.Дагвадорж тэргүүтэй албаны хүмүүс оролцлоо.

Энэ үеэр нэр дэвшигч Х.Баттулга “Цэрэг дайчдынхаа амрыг эрье. Сонгуулийн сурталчилгааны ажлынхаа хүрээнд ес дэх аймагтаа ирээд байна. Эх орноо нар зөв тойрч явахдаа аймаг бүрийн цэргийн анги нэгтгэл, цэрэг дайчдыг онцлон үзэж, уулзаж ярилцахыг хичээж яваа билээ. Надад сэтгэлдээ тээж, бодолдоо зураглаж явдаг нэгэн мөрөөдөл бий. Энэ бол Монгол Улсын Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, дайчид нөхөд та бүхэн энх цагт эх орныхоо бүтээн байгуулалтад гар бие оролцож, үйлдвэржсэн хүчирхэг Монгол Улсыг бүтээн байгуулаасай гэх хүсэл. Эл хүслээ би мөрийн хөтөлбөртөө багтааж, нэлээд тодорхой тусгасан байгаа. Өнөөдөр манай залуучууд нэг жилийн хугацаатай алба хааж байна. Хэрэв “Нэг цэрэг-Нэг үндэстэн” хөтөлбөр хэрэгжиж эхэлбэл хугацааг 1-3 жил болгож, цэрэг дайчид алба хаах хугацаандаа сар бүр сая төгрөгийн цалинтай ажиллаж, халагдахдаа орон сууцтай, хуримтлалтай болох боломжоор хангах юм. Үүгээр ч зогсохгүй, гурван жилийн хугацаанд хос мэргэжил эзэмших, цаашид мэргэшил боломж бүрдэнэ. Манай орон харьцангуй эрс тэс уурамьсалтай. Тиймдээ ч халуун дулааны улиралд нь гадаах бүтээн байгуулалтын ажлаа өрнүүлж, хүйтэн сэрүүний улиралд нь онол, практик хосолсон байдлаар танхимын боловсрол эзэмшиж, хос мэргэжилтэй болох боломжтой юм. Улмаар сайн дураар 1-3 жилийн алба хаасан залуус халагдахдаа орон сууцтай, эзэмшсэн мэргэжилтэй гэртээ харина. Гурван жилийн хугацаанд мэргэжил эзэмшээд, гэр оронтой болоод харьж буй хорин хэдтэй хүүхдүүд гэр бүлийнхнийхээ хувьд энх цагийн баатар биш гэж үү.

Энэ бүхэн хийх хоосон төсөөлөл биш ээ. Ганцхан жишээ дурдахад Израил улс яг энэ зарчмаар өдгөө үсрэнгүй хөгжлийн замд гарч, дэд бүтцийн хөгжлөө богино хугацаанд сэргээн босгож, үйлдвэржсэн орон болоод байна. Энх цагт цэрэг дайчдаа бүтээн байгуулалтад татан оруулдаг энэ жишиг дэлхийн олон оронд амжилттай хэрэгжсэн” гэв. Нэр дэвшигчийн эх орноо тойрч буй дараагийн зогсоол түүний төрсөн нутаг Баянхонгор аймаг байлаа. Тэрбээр Өвөрхангай аймгийн иргэд, сонгогчидтойгоо уулзсаны дараа өөрийн төрсөн нутаг болох Баянхонгор аймагт очив. Түүнийг нутгийн зон олон нь халуун дулаанаар хүлээн авсан юм. Мөн сонгогчидтой хийх уулзалтад төв стадион дүүрэн нутгийн иргэд цутгаж, нэр дэвшигч Х.Баттулгыг дэмжиж буйгаа илэрхийлж байлаа.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2017-06-13

Тендер шалгаруулалтын нэр: “Үрийн аж ахуйн техник, тоног төхөөрөмж” нийлүүлэх
Тендер шалгаруулалтын дугаар: ХХААХҮЯ-Б-2017/02/ҮТТ

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь эрх бүхий тендерт оролцогчдоос **үрийн аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх** тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийгбичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 100000 /зуун мянга/ төгрөгөөр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн сан банк дахь 100900019002 тоот дансанд тушаан авч болно.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна. Тендер нь дараах 3 багцтай байна:

Багц 1. Трактор, үр тариа хураах комбайн тус бүр 2 ширхэгийг нийлүүлэх,

Багц 2. Чиргүүл, дүүжин машин/сийрүүлүүр, үрлүүр, хор цацагч/ 2 иж бүрдлийг нийлүүлэх,

Багц 3. Утрэмийн машин / үр сортлогч/ 2 иж бүрдлийг нийлүүлэх

Тендерийн хамт өөрийн санал болгож байгаа үнийн дүнгийн 1 хувьтай тэнцэх хэмжээний тендерийн баталгааг төгрөгөөр ирүүлнэ.

- Сүүлийн 2 жилийн борлуултын орлогын дундаж нь санал болгож буй үнийн дүнгийн 60.0 хувиас багагүй байна.
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон эзэлжих эрх нээлгэсэн зээлийн хэмжээ санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.
- Сүүлийн 2 жил буюу 2015, 2016 оны Аудитаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайланг ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 15 цагаас 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2017 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 15 цаг 20 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

ХАЯГ:

**Монгол улс, Улаанбаатар хот, Энх тайвны өргөн чөлөө 16А,
Засгийн газрын 9 дүгээр байр, ХХААЯ-ны 503 дугаар өрөө
Утас:263408 Факс: 263237**

АЯНЫ БОГЦ

АЯН ЗАМЫН ТЭМДЭГЛЭЛ

Жэк Ма, Алибаба ХОЁРООРОО ГОЁХ ханжоучууд

Төгсгөл.
Түрүүч нь I нүүрт

Зам дагуу ургасан сарнайн бут өнгө алаглан салхины аясаар ишин дээрээ найгаад л. Болдогсон бол автобусаа зогсоож байгаад бутан дунд хэсэг амсхиймээр л санагдаж байлаа. Торго, цайгаараа алдартай Ханжоуд жирийн хятад залуу мөрөөдлөө биелүүлэхээр хөл тавьсан нь хожим дэлхийд алдар суугаа мандуулсан нэгэн болох юм гэж тэр үед хятадууд зүүдлээ ч үгүй биз. Тэр эрхэм бол дэлхийн нөлөө бүхий 30 бизнесмений нэг, та бидний сайн мэдэх Жэк Ма. Гадаадын жуулчдад хөтөч хийж явсан Жэк Ма гурван нөхрийн хамт “Алибаба” группыг 1999 онд орон сууцны нэг өрөөнд байгуулсан түүхтэй юм билээ. Түүхэн агшныг өгүүлэх фото зураг “Алибаба” группын төв оффисын үүдээр оронгуут өөдөөс чинь тосох вий. Тэр үед ноён Жэк Ма дөнгөж хорь гарч яваа дэлчгэрхэн хүү байсан нь фото зургийн хальснаа мөнхрөн үлджээ. Дэлхийг араасаа дагуулж буй “ Алибаба” групп 2014 оны есдүгээр сарын 19-нд Нью-Йоркийн Хөрөнгийн биржид хувьцаагаа анх гаргаж, тэр өдөртөө 230 тэрбум ам.долларт хүрсэн удаатай. “Нарт тэнгэрийн дор бидэнд хийж чадахгүй бизнес гэж үгүй” хэмээсэн түүний үг зөвхөн “Алибаба” группынхны уриа бүс бизнес эрхэлж буй хэн бүхний хамгийн түрүүнд санаж явах зүйл болсон талаар тус группын хөтөч бидэнд омог бардам өгүүлсэн. Тиймдээ ч алибабачууд эцэс төгсгөл гэж үгүй цахим ертөнцийн сүлжээнд “хаанчлах” болсон буй за. Хөтөч менежерийн өгүүлснээр, сүүлийн жилүүдэд жил бүрийн арваннэгдүгээр сарын 11-ний өдрийг тив, тивийн сая сая хэрэглэгчид гэсэн ядан хүлээдэг болсон гэнэ. Монголын цахим худалдаачид ч ялгаагүй. “Алибаба” групп тэр өдөр тэрбум юанийн орлогот олсон аж. Аж ахуйн нэгжийн хувьд энэ бол маш том амжилт. Бас гайхамшиг ч гэж нэрлэж болно. “Алибаба” групп өнгөрсөн жилийн яг энэ өдөр тодруулбал 120 тэрбум юанийн орлоготой ажиллажээ.

Нэгхэн өдөрт шүү дээ. Тус группээс гаргасан статистик мэдээллээр, уг их наадамд нийт 235 орны бизнесмэнүүд хүрэлцэн ирж оролцдог юм байна. Энэ оны зургаан сарын байдлаар 376 тэрбум 7 сая задгай бараа зарагджээ. “Та худалдан авч чадвал бид хүргэж чадна” гэсэн уриатайгаар ажилладаг алибабачууд эх орондоо 24 цаг, дэлхийн бусад оронд 72 цагийн дотор бараа бүтээгдэхүүнээ хүргэдэг гэдгээрээ бахархаж байсан. Монголын сэтгүүлчид цаст Гимлай дахь худалдан авагчийг ч мартаагүй хэмээн тэргүүхэндээ томорсон нь Улаанбаатар бол асуудал биш гэсэн санааг давхар агуулсан хэрэг. Гимлайд хүрэхийн тулд Алибабагийн улаач өртөөгөөс өртөө дамжин довтолгодог аж. Улаа нэхэх гэдэг чухамдаа бидний өвөг дээдсийн санаа шүү дээ. Хүн төрөлхтөн хөгжлийнхөө дээд шатанд яваач Чингисийн Монголын ухааныг барж идэх болоогүй гэдэг нь энэ мэтээс харагдах юм даа. Тус компанид эдүгээ 830 мянга хүн ажилладаг юм байна. Жэк Ма ажлын байрны тоог 100 саяд хүргэх зорилго тавьжээ. Алибабачууд цахим худалдааны хаан болох хүсэлдээ хөтлөгдөж, хэн хүний санаанд багтамгүй үүлэн тооцооны аргыг дэлхийд нэвтрүүлэхээр зорьж байгаагаа сонирхуулсан. Монголчуудын хувьд шинэ нэр томъёо. Магадгүй зарим нь үүл гэхийг бодвол хий хоосон хийсвэр тооцоо гэж ойлгохыг үгүйсгэхгүй. Нэдэр дээрээ энэ нь дэлхийн хэмжээнд ашиглаж буй статистик тоо баримтыг хэдэн “настай”, үнэн зөв эсэхийг магадлан шинжлэх гэнэ. Мөн банкны системийг ашиглаж том, жижиг аж ахуйн нэгжүүдэд эзэл олгох боломж олгон, аксет бөглөнөөс хойш гурван минутын дотор данс руу нь мөнгө шилжиж орох, гар утсаараа захиалга өгөөд урьдчилгаа төлбөр төлөхгүйгээр эзэл авах зэрэг шинэ үйлчилгээ юмсанж. Дашрамд сонирхуулахад, 2014 онд байгуулагдсан КТМ компани 17 сая 600 мянган юаний



орлого олсон бол “Алибаба” сайттай хамтарч ажилласнаар орлого нь 2016 онд 180 сая юань болтлоо өссөн гэдгийг аялалын төгсгөлд онцлон дурьдсан.

Эцэст нь дүгнэж хэлэхэд, Бээжингийн гудамжаар ажил эрэн бэлдэж явсан залуу гурван найзаа дагуулан Ханжоуг зорьж байсан тэр цаг түүх болон үлдэж, Жэк Ма, Алибаба хоёр дэлхийд танигдсан төдийгүй Хятад улс энэ хоёроороо гоёж байгааг харж, мэдэрч явах сайхан байлаа.

Буудайн агуулахаас мэдээллийн инкубатор

Бидний дараагийн маршрут “Мөрөөдөл”-ийн хотхон байлаа. Аялалын маршрутад “Dream” балгастай танилцана гэж тэмдэглэсэн байсан юм. Үүнийг уншаад балгастай танилцах хэрэг үү. Балгас атлаа юун гоё нэртэй юм. Мөрөөдөл энэ тэр гээд л. Хэддүгээр зууны үеийнх юм бол. Манай Хубилай хааны үеийнх юм биш байгаа гэж ирээд л дөнгөсч явсныг яана. Гэтэл балгас гэдэг маань бидний мэдэх сеносон эртний барилгын туурь биш хотхоныг хэлдэг юмсанж. “Dream” балгас чухамдаа амар амгалангийн туйл болсон газар байлаа. Бээжингээс эх аван мянган бээр замыг туулан Ханжоу хотын дундуур урсах их голын түрлэг, модод дамжин шулганалдах шувуудын жиргээтэй хослоод л. Хүн ийм л нөхцөлд бүх анхаарлаа хийж байгаа зүйл рүүгээ төвлөрүүлж чаддаг байх. Тэр хэрээр хятад нөхдийн зорьж, зүтгээд байгаа инноваци нь ч төрөлгүй ч яах вэ. Цагтаа амуу буудайн үтрэмийн агуулах байсан энэ газар эдүгээ Хятадын мэдээллийн технологийн инкубатор болжээ. Агуулах байсных нь гэрч болгож байшингийн дэвэрийн хэлбэр дүрснийг өөрчлөлгүйгээр тэр хэвээр нь үлдээсэн байна лээ. Манайхан үтрэмийн агуулах байсан гэж хэлэхээсээ ч ичиг үхэх байх даа. Гэтэл тэд бахархаж байх жишээний. “Мөрөөдөл”-ийн хотхоны гол хаалганы өмнө олон сая шувуудын дүрс бүхий далавч дэвэн байх нь хотхоныхны байдал аж. Албан ёсоор өгсөн мэдээлэлд дурдсанаар, “Мөрөөдөл” хотхон 990 гаруй төслийг Засгийн газартаа өргөн бариад байгаа бөгөөд уг төсөлд 9400 аж ахуйн нэгж хамрагдсан байна. Он гарсаар сая гаруй юанийн санхүүжилтыг 110 гаруй төсөлд олгожээ. Ингэхдээ Засгийн газар дэмжсэн төслүүддээ

санхүүжүүлэхийн зэрэгцээ хэрэгжүүлэх аж ахуйн нэгжүүдээ байрыг нь үнэгүй хангадаг гэсэн. “Bay west-Best way буюу Баруун эрэг-Хамгийн хүчирхэг зам” гэсэн уриа бүхий логон дээр АНУ-ын баруун эргийг дүрсэлсэн нь хятад хүний холыг харсан нүүдэл буй за. Мөрөөдөл нь ч гэж болох байх. Тайлбарлагч бүсгүйн хэлснээр, “Мөрөөдөл” хотхон 280 гаруй интернэт компанийн инкубаторт бойжуулсанаас 50 нь Хятад улсын хэмжээнд үйл ажиллагаагаа амжилттай үргэлж байгаа хэмэсэн. Дотроо 30 гаруй салбартай тус хотхоны улсынхаа өмнө хүлээсэн бас нэг үүрэг нь ухаалаг программыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх явдал. “Мөрөөдөл” хотхоны менежерээс “Та бүхэн санхүүжүүлэх компаниа хэрхэн сонгодог вэ” гэж сонирхоход “Тухайн компанийн хөрөнгийн үнэлгээ 50 сая юаниас доош тохиолдолд санхүүжилт үзүүлдэг” гэсэн юм. Үүнийг манайхан бодолцоход гэмгүй.

Газрын диваажин болсон Ханжоугийн бас нэг бахархал бол Дунчон инновацийн хотхон. Өмнө нь цементийн үйлдвэр байсан гэж хэлэхэд гайхах хүн олон байсан. Нарсан ойтой тун төстэй модон дунд орших хотхоныхон үүлэн тооцооны үйлчилгээг дэлхийд санал болгохоор ажиллаж байгаа аж. Сүүлийн үед Хятад улс үүлэн тооцоогоор амьсгалж буйг энд онцлон тэмдэглэх хэрэгтэй болов уу. Дунчон инновацийн хотхоны хувьд үүлэн тооцооны үйлчилгээ хаана хэрэгтэй байна тэнд хүрч үйлчилнэ гэсэн үг. Дунчон инновацийн хотынхон үүлэн тооцооны үйлчилгээнээс гадна олон гайхамшигтай бүтээгдэхүүнийг санал болгож байна лээ. Тухайлбал, 14.8 грамм хөнгөхөн ухаалаг балыг нэрлэж болно. Хэрэглэгч та суудал дээрээ буруу суугаад энэ бачаар бичих гэвэл хошуу нь яаж ч оролдоод гарч ирэхгүй зовооно. Харин зөв цэх суух аваас хошуу тэр дороо гарч ирнэ. Зүгээр суу, хичээлээ хий гэж байнга үглэж байдаг эцэг, эхчүүдэд мөн ч хэрэгтэй зүйл байгаа биз. Бас ширээ байна лээ. Үйлдэл нь ялгаагүй. Хичээл хийж буй тохиолдолд ширээний тавигч 90 хэм байх бол зөгнөлт хийгээд утга зохиолын ном унших аваас автоматаар налуу болдог гэж байсан. Үнэ нь хоёр сая юань. Хэрэв авахыг хүсвэл Алибабагийнханд хандахад л асуудал шийдэгдэж таарна. Үүнээс гадна савтай усан дотор утас цэнэглэж буй залуурыг дүрсэн байлаа. Уг залуур ямар ч тохиолдолд ажиллах гэнэ.

...Хятад улс юуг эдийн засгийн эргэлтэд оруулахаа тун сайн мэдэх юм. Манайхан шиг шинээр бүтээсэн зүйлээ эвдэрч хэмхэрхэхээс нь айгаад таг цоожилчихдоггүй юм байна. Уг ордныг үзэж сонирхохыг хүссэн хэн бүхэн 100 юанийн такс төлөөд л дотогш нэвтрэх эрхтэй болно. Залуус хуримаа ч хийж болох аж. Хийж ч байгаа байх...

Цахилгаан цохих, утас шатах аюулгүй гээд төсөөлдөө. Усгоожих юу ч биш бололтой. Бас нами будаагаар үсийг нь хийсэн шүдний сойз, эзэнтэйгээ зэрэгцэн “алхах” ухаалаг чөмөдөн, ухаалаг самбар гээд амаа ангайн гайгах зүйлийг тэнд дэлгэжээ. Унадаг дугуй битүү хийсэн, хилгээр хориотой бараа бүтээгдэхүүн авч орохыг оролдсон хүнийг царайных нь хувирлаар дор нь илрүүлдэг шидтэй эд аж. Гэмт хүн гэлбэлдэг болохоор ямар нэг байдлаар сандарч тэвдэг л байх. Бас жолоочгүй машиныг бидэнд сонирхуулсан. Машинаа суугаад л хүрэх газраа хүртэл унтаж ч болох аж. Хүний машинд дайгдсантай адил юм уу даа. Түүнд гэрэл чийдэн

буюу инновацид зориулж, тэр хэрээр улс орон нь хөгжиж байгааг хараад атаархахгүй байхын аргагүй. Заримдаа ч өөрсдийн салгар наазагй байдлаа бодоод уур хүрч явлаа.

Монголын сэтгүүлчид “Их-20”-дсон нь

“Их гүрнүүдийн буюу “Их 20”-ийн уулзалт Хятадын Ханжоуд болж өнгөрснийг та бүхэн мартаагүй нь лавтай. Монгол Улсын Ерөнхийлөгч Ц. Элбэгдорж АСЕМ-ийг эх орондоо амжилттай зохион байгуулсан шиг БНХАУ-ын дарга Си Зиньпин дэлхийд нөлөө бүхий хорин улсын төрийн тэргүүнийг ажиллаж амьдарч байсан хотдоо хүлээн авсан юм. Нүсэр их ажлын ард амжилттай гарсан ханжоучууд 2020 оны өвлийн олимпод бэлдээд завгүй байгаа бололтой. “Их 20”-ийн уулзалт болсон газартай залгаад шахуу цэгцрийн дэлбээ бүхий хийц загвартай спортын орднуудыг барьж байна лээ. Эхний хэсэг нь ашиглалтад орсон байх гэмээр харагдаж байсан. Хараа булааж, уулга алдах ч юу ч биш тийм сайхан орд харшийн үүдийг Монголын 22 сэтгүүлч татсан. Тодруулбал, МСНЭ-ийн ерөнхийлөгч Б.Галаарид тэргүүтэй сэтгүүлчид “Их 20”-ийн морилсон ордонд монгол хүний хөлийн мөрийг үлдээж амжсан. Өндөр өртөг зардлаар боссон нь хаалга, хана тулгранах нь гоёл чимэглэл, хээ хуар, тавилга сэлт, хивс зэргээс нь харагдах энэхүү ордныг эртний Хятадын сонгодог ч үүрэг гүйцэтгэдэг гэдгийг гэд хэдийнэ олж харсан хэрэг. Үүнийг батлах мэт “Хөшгөө хэзээ ч хаахгүй” хэмээх уриатай урлагийн хотхоны зоогийн газарт сэтгүүлдчийг урив. Манай томоохон ресторанаас дутахааргүй тус зоогийн газрын хаалгыг татахад номын санд орж ирсэн мэт сэтгэгдэл төрсөн. Дэлхийн бүх хэл дээр хэвлэгдсэн сонгодог зохиолууд тэнд байгаа гээд төсөөл дөө. Зоогийн газрын менежер “Заан уулын урлагийн бүсэд дэлхийн урлаг соёлын алдартнуудыг урьж, бүтээлээ туурвихад нь туслах нь бидний зорилго” гэсэн юм. Тун удахгүй , Дунчон инновацийн хотхон “Азийн Холливуд” болсон байхад гайхах зүйлгүй. Дунчон хотынхон чадварлаг, туршлагатай эрдэмтэд, бичгийн хүмүүс, урлаг соёлынхны өмнө “хөшиг”-өө үргэлж нээлттэй байлгахгаар хичээн ажиллаж байгааг монголчууддаа дуулгахад таатай байна. Монголын кино олдыг алс холын Америк тив сонирхоод эхэлснийг урд хөршинхөн маань анзаарсан байлгүй. Эсвэл хэн нэг маань хэдийнэ оччихсон бүтээлээ туурвиж байж ч мэдэх юм. Гадны зочид ч цөөнгүй байгаа гэсэн. Нөгөөтэйгүүр, биднийг гар утастайгаа ноцолдон, тоглоом тоглож, цахим ертөнцөөр өөр зуураа хэрэлдэж байх зуур шинэ зууны хятад залуучууд минут секунд бүрийг шинэ содон санаа

Улаанбаатар-Бээжин-Хан Жоу хот. Үргэлжлэл бий

НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААНЫ ЗАР

“Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 240 дугаар тогтоолоор УАЗ 220692-033 Пургон маркын автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахаар шийдвэрлэв.

1. Дуудлагаар худалдах хөрөнгийн танилцуулга

д/д	Автомашины марк	Улсын дугаар	Үйлдвэрлэсэн он/ ашиглалтад орсон он	Худалдах доод үнэ	Дэнчингийн хэмжээ
1	Уаз220692-033 / пургон/	61-53 УБӨ	2007/2007	2,500,000	625,000

2. Дуудлагын худалдааны ерөнхий мэдээлэл:

Дуудлагын худалдаа болох хугацаа	2017 оны 06 дугаар сар 30-ны 10:00 цаг
Дуудлага худалдаа болох газар	Дорнод аймгийн Авто тээврийн төв байр
Худалдах доод үнэ	2,500,000 төгрөг
Дэнчингийн хэмжээ	625,000 төгрөг
Худалдах, худалдан авах гэрээний ерөнхий нөхцөл	Худалдан авагч нь дуудлага худалдаагаар худалдан авсан эд хөрөнгийн үнийг 14 хоногийн дотор төлнө.
Дэнчинг байршуулах данс	Хүлээн авагч байгууллага: “Автотээврийн үндэсний төв” ТӨҮТ Банкны нэр: Төрийн банк Дансны дугаар: 340004009911

3. Дуудлагын худалдаанд хүсэлт ирүүлэх

Дуудлагын худалдаанд оролцох хүсэлтийг 2017 оны 06 дугаар сар 30-ны 10:00 цаг хүртэл Дорнод аймаг Хэрлэн сум 6-р баг, Дорнод аймгийн Авто тээврийн Төв, 2-р давхар 03 тоот өрөөнд хүлээн авна.Хугацаа хоцорсон хүсэлтийг хүлээн авах боломжгүйг анхаарна уу.

4. Худалдах хөрөнгийн талаар мэдээлэл авах

Дуудлага худалдаагаар худалдах хөрөнгийг үзэж болох бөгөөд холбогдох мэдээллийг 99835185 дугаарын утсаар авч болно.

Дорнод Аймгийн Автотээврийн Төв

ДЭЛХИЙ

Милания Трамп Цагаан ордон руу нүүжээ

АНУ-ын тэргүүн хатагтай Милания Трамп эцэст нь нэг Нью-Йоркийн Манхеттэны тэнгэр баганадсан “Trump Tower”-ээс хүү 11 настай Баррон Трампын хамт Цагаан ордонд нүүж иржээ. Өнгөрсөн жил болсон АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд БНН-аас нэр дэвшсэн Доналд Трамп ялалт байгуулж, нэгдүгээр сарын 20-нд тангарагаа өргөснөөс хойш тэргүүн хатагтай Цагаан ордонд амьдраагүй юм.

Улмаар бага хүү Барроны хичээлийг таслуулахгүй гэсэн шалтгаанаар улирлын амралт хүртэл нь Нью-Йоркт амьдрана гэдгээ өмнө нь мэдэгдээд байв. Гэвч, Д.Трампын гадаад улс оронд хийсэн анхны айлчлалын үеэр Милания нөхөртэйгөө хамт явахаас татгалзаж, хөтөлцөлгүй гарыг нь алгадах, бултуулах гэх зэрэг үйлдэл гаргаж, АНУ-ын төрийн тэргүүний гэр бүлийн амьдрал олны анхаарлыг татах болсон.

Бүр Милания, Трамп нар гэрээ байгуулсан, тэргүүн хатагтай өөр нууц амрагтай гэх мэдээлэл ч гарсаар байгаа юм. Харин Цагаан ордон уг мэдээллийг эрс няцааж байгаа бөгөөд эцэст нь буюу энэ сарын 11-нд хатагтай Милания Нью-Йорк дахь гэрээ орхиж, “Эйр Форс-1” хувийн хэрэглээний онгоцоор Вашингтонд газарджээ. Барроны сургуулийнх нь амралт ч эдүгээ эхэлсэн гэнэ. Мөн шинэ хичээлийн жилээс Баррон Трамп Вашингтоны Гэгээн Эндрюгийн сургуульд суралцахаар болжээ.

Милания АНУ-ын түүхэн дэх анхны Цагаан ордноос өөр газар амьдарч байсан тэргүүн хатагтай болж байсан юм. Түүнчлэн, тэргүүн хатагтай өөрийн твиттер хуудсаараа дамжуулан Цагаан ордон руу нүүж байгаадаа тун баяртай байгаагаа илэрхийлээд амжжээ. Тэрбээр Ерөнхийлөгчийн орды цонхоор авсан зургаа нийтэлж, “Шинэ гэртээ гэр бүлээрээ сайхан амьдрах төр мөчийг би тэсэн ядан хүлээж байна” гэх тайлбарыг зүүсэн байв. Түүнийг ээгүйд охин Иванка Трамп олон улсын албан уулзалтад Миланияг орлож байсан юм.



Э.Макроны НАМ ҮНЭМЛЭХҮЙ ЯЛАЛТ БАЙГУУЛЛАА

Б.ДАВАА

Францын Ерөнхийлөгчийн сонгуульд хэний ч мэдэхгүйнамыннэрдэвшигчялалт байгуулсан билээ. Байгуулагдаад ердөө нэг жил болж буй шинэхэн улс төрийн хүчнээс нэр дэвшсэн Эммануэль Макрон зөв менежмент ашиглан сонгуулийн сурталчилгаагаа явуулж, үр дүнд нь Францын Ерөнхийлөгч болсон. Тэгвэл энэ сарын 11-нд тус улсын парламентын доод танхимын эхний шатны санал хураалт болж, Макроны төвийн үзэл баримтлалт “Урагшаа” нам болон түүний холбоотон болох төвийн үзэл баримтлалт улс төрийн хүчин “MoDem” нийтдээ 32.32 хувийн дэмжлэг авч, олонх

болох нь нэгэнт тодорхой болжээ. Францын Дотоод хэргийн яамнаас сонгуулийн эцсийн үр дүнд өчигдөр өглөө 01:30 цагт зарласан юм. Улмаар “Урагшаа” нам болон Ардчилсан холбоо нам нийтдээ парламентын 577 суудлын 400-445-ыг авах төлөвтэй байгаа юм. Харин Францын эрх баригч хүчин болох Социалистууд энэ сонгуулиар 200 суудлаа алдлаа.

Макроны нам ердөө нэг жилийн өмнө байгуулагдсан. Тиймдээ тус намаас доод парламентад сонгогдсон гишүүд улс төрийн ямар нэг туршлагагүй “бор халзан хонинууд” байгаа юм. Гэхдээ эцсийн үр дүн дараагийн долоо хоногийн нам гарагт болох хоёр дахь шатны санал хураалтаар эцэслэн шийдэгдэх билээ.

Саналын хуудсыг бүгдийг тоолж дууссаны дараа Макроны LREM болон MoDem нам 32.3 хувийн санал авсан бол төв барууны үзэл баримтлалт Бүгд найрамдахчууд 21.5 хувь, Үндэсний Фронт нам 13.2 хувь, эрх баригч Социалистууд энэ удаа ердөө 9.5 хувийг санал тус тус авсан байна. Энэ үзүүлэлтээр Бүгд найрамдах нам доод парламентад 70-130 суудал авах магадлалтай юм. Харин Ерөнхийлөгчийн сонгуульд Макронтой өрсөлдсөн Марин Ле Пенний Үндэсний фронт нам 1-10 суудал авна гэж шинжээчид үзэж байна.

Марин Ле Пен парламентын анхан шатны сонгуульд Ерөнхийлөгч Эммануэль Макроны өнгөрсөн жил

байгуулсан шинэхэн нам ялалт байгуулсан явдалтай холбоотойгоорулсынхааиргэдийг улс төрийн идэвх муутай байна гэж шүүмжилжээ. Ерөнхийлөгч Макроны нам өөрчлөлт шинэчлэл хийхийн тулд их хуралд олонхи суудлыг авах зорилго тавиад байсан юм.

Тэр ч үүднээс сонгуулийн дүн сүүлийн 10 жилийн турш эрх барьсан намуудад ахин нэг томоохон цохилт болсныг олон улсын хэвлэлүүд онцолж байна. Үүнтэй холбоотойгоор Францын Ерөнхий сайд Эдуард Филипп “Франц улс эргэн ирлээ” гэж мэдэгджээ. Улс төр судлаачид Макроны эвслийн нам сүүлийн шатны сонгуульд сонгогчдын дөрөвний гурвын дэмжлэгээр 400-

440 суудал авч, ялалт байгуулах магадлалтай байна гэж үзэж байгааг “Ройтерс” агентлаг онцолжээ. Тэдний гол өрсөлдөгч нь бүгд найрамдахчууд байх бөгөөд 100 орчим суудал авч магадгүй гэж шинжээчид үзэж буй юм байна. Нөгөөтэйгүүр экс Ерөнхийлөгч Франсуа Олландын Социалист нам өмнөхөөсөө 200 суудлаа алдаж, намаасаа Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшихээр өрсөлдсөн Бенойт Хамон хүртэл хоёр дахь шатны сонгуульд үлдэж чадаагүй байна. Сонгууль хоёр үе шаттай бөгөөд ирэх нам гарагт буюу зургаадугаар сарын 18-нд Үндэсний ассемблейн доод танхимын 577 гишүүнийг сонгох сонгуулийн хоёр дахь үе шат явагдах юм.

АНУ-ын төрийн далбаанд нэг од нэмэгдэх үү



Пуэрто Рико арал дээр өчигдөр АНУ-ын 51 дэх мужийн статустай болох эсэх талаар бүх нийтийн санал асуулга явуулжээ. Санал асуулгаар тус арал АНУ-ын харьяа хэвээр

үлдэх үү, эсвэл бие даасан тогтолцоотой болох уу гэдгийг шийдсэн байна.

Санал асуулгын дүнд хагас сая орчим иргэн хараат бус тогтолцоотой болохыг дэмжсэн бол, 7600 иргэн хагас автономн засаглалыг дэмжиж, 6700 орчим иргэн одоогийн байгаа статусыг дэмжжээ. 2.26 сая иргэн санал өгөх ёстой байсан ч ердөө 23 хувь нь санал өгсөн бөгөөд улс төрийн хэд хэдэн нам тус асуудлыг хэлэлцэх шаардлагагүй гэж үзэж, санал өгөхөөс татгалзсан байна. Бүх нийтийн санал асуулга

явуулахыг тус арлыг АНУ-ын бүрэлдэхүүнд шинэ муж улсаар оруулахын төлөө бодлого явуулдаг нам дэмжиж байгаа юм. Тус намын төлөөлөгчид энэ нь Пуэрто-Рико-д санхүүгийн ноцтой хүндрэлээс гарахад нь туслана гэж үздэг байна. Тус улсын иргэдийн өгсөн санал нь заавал биелүүлэх шийдвэр биш бөгөөд, АНУ-ын Конгрессийн хувьд зөвлөх шинж чанартай аж. Гэхдээ АНУ-ын конгресс Пуэрто Рико арлын улс төрийн статуст өөрчлөлт оруулах эсэх асуудлыг эцэслэн шийдвэрлэх юм.

Хятадын агаарын тээврийн онгоц ослын буулт хийв

Австралийн Сидней хотын нисэх онгоцны буудлаас хөөрсөн БНХАУ-ын иргэний агаарын тээврийн “China Eastern Iarlines” компанийн зорчигч тээврийн онгоцны нэг хөдөлгүүрийн гаднах бүрхүүлд том нүх гарсантай холбоотойгоор хөөрөөд удаагүй байхдаа ослын буулт хийсэн байна. Энэ талаар тус компаниас өчигдөр мэдээлжээ. MU736 загварын нисэх онгоц орон нутгийн цагаар энэ сарын 11-ний өдрийн өглөө 08:30 цагт Сиднейн нисэх онгоцны буудлаас хөөрчээ. Гэвч, онгоцны зүүн талын хөдөлгүүрийн гаднах бүрхүүлд эвдрэл гарсантай холбоотойгоор нисэх буудлын ажилтнууд ойролцоох зорчигчдыг өөр суудал руу шилжүүлж, улмаар Сиднейн нисэх буудалд ослын буулт хийсэн байна. Энэ үеэр гэмтэж бэртсэн зорчигчид байхгүй аж. Онгоц Эйрбус А330 загварынх байжээ. Тухайн үед онгоцонд зорчиж явсан нэгэн иргэн “Хөөрчихлөө гэж бодож байтал гэнэт л зүүзүү гэж дуугарах чимээ сонсогдсон. Бас ямар нэг зүйл шатаж буй мэт үнэр үнэртсэн” гэж “Долдугаар суваг” телевизэд ярьсан байна.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

“РАДИО КОНКУРС”-ЭЭР БАГШ БОЛОХ МӨРӨӨДЛӨӨ БИЕЛҮҮЛЖЭЭ

Г.ГАНЧИМЭГ

Удахгүй элсэлтийн ерөнхий шалгалт болох гэж байгаа. Энэ л үед хүүхэд залуус ирээдүйд ямар мэргэжилтэй болох вэ гэдгээ сонгодог. Тэр дундаа “Багш шигээ сайн багш болно” гэдэг нандин мөрөөдөл цөөнгүй сурагчдад бий. Харамсалтай нь өнөөдөр манай улсын бүх шатны боловсролын байгууллагад багшлах боловсон хүчний нөөц төдийлөн хангалттай биш. Тэр дундаа манай улсын өнцөг булан бүрт ерөнхий боловсролын сургуулийн бага ангид багшлах 7800 хүний нөөц хэрэгтэй байгаа аж. Нөгөөтэйгүүр, багш болох чин хүсэл эрмэлзлэлтэй, сурлага сайтай ч ар гэрийн боломж тааруу байх тохиолдол ч бий. Ийм нөхцөл байдлыг судалж үзээд багш болох чин хүсэлтэй хүүхдүүдэд нэгэн сайхан боломжийг МУБИС, МҮОНР хамтран зохион байгуулсан “Радио конкурс” уралдаант нэвтрүүлгээрээ олгосон юм. Өнгөрсөн хоёрдугаар сараас эхэлсэн “Радио конкурс” уралдаант нэвтрүүлгийг Хэнтийн аймгийн Биндэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн сурагч А.Минжинсор тэргүүлж, Архангай аймгийн Батцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн сурагч Д.Нямдулам хоёрдугаар байранд оржээ.

МҮОНР-ийн Хүүхэд залуучуудын редакцийн продюссер Ц.Сосорбурам “Уралдаант нэвтрүүлэгт идэвхтэй оролцсон нийт хүүхдүүддээ баяр хүргэе. “Радио конкурс” уралдаант нэвтрүүлэгт түрүүлсэн сурагчийг МУБИС-д элсэн сурах урилгаар шагналаа. Мөн эхний нэг жилийн сургалтын төлбөрөөс 100 хувь чөлөөлөгдөх эрхийг олгож байна. Харин II байранд орсон хүүхдийг эхний нэг жилийн төлбөрөөс 50 хувиар чөлөөлж, мөн урилгаар тус сургуульд элсэн сурахдаа эрхийг олгож байгаа юм. Үүнээс гадна уралдаанд идэвхтэй оролцсон 15 хүүхдэд босго оноогоо давчихвал энэ сургуулийн дуртай ангиа сонгон сурахдаа эрхийг олгож батламж гардууллаа. Багш хүн бол сурган хүмүүжүүлэгч, сэтгэл судлаач байдаг. Хүүхдийг эрдэм мэдлэгтэй хүн болгохоос гадна гараас нь хөтөлж хүн болгох адармаатай



хэр нь аз жаргалтай эрхэм үйлсийн эзэд байдаг учраас багш болох хүн завсар зуурын сонирхлын журмаар энэ мэргэжлийг сонгоно гэдэг нь өрөөсгөл, учир дутагдалтай. Тиймээс манай хоёр байгууллага ярилцаж хэлэлцээд өрөөсөө хөдөө, орон нутагт ч бай, хот, суурин газарт ч бай багш дутагдалтай газарт багш болох чин хүсэл эрмэлзлэлтэй хүүхдүүдийг л энэ уралдаанаар олж илрүүлж, сонгон шалгаруулах зорилго тавьсан юм. Бид 10-аад жилийн өмнө “Радио

конкурс” уралдааныг Санхүү, эдийн засгийн сургуультай хамтран зохион байгуулж байлаа. Тухайн үед гурван хүүхдэд тус сургуульд элсэн сурахдаа эрх олгож байсан.

Харин өнөөдөр багш болох туйлын хүсэл, чин сэтгэлтэй хүүхдүүдийг олж нээн мөрөөдлийг нь биелүүлжээ. Хүүхдүүдэд хувь заяагаа шийдэх ийм сайхан боломж олгоно гэдэг бол ирээдүйн багш нарын амьдралын замналыг нээж өгч буй сайхан гарц юм”

гэлээ.

“Радио конкурс” Монгол орон даяар зарлагдаж 18 аймгийн төв, сум суурин төдийгүй нийслэл хотын Ерөнхий боловсролын сурагчид ч идэвхи чармайлттай оролцжээ. МҮОНР ч хүртээмжтэй хүрч, шууд нэвтрүүлгээр хүүхдүүдийн бодит, бүтээлч оролцоог дэмжиж, тэдэнд байж болох бүхий л боломжийг олгосон юм байна.

Цагаа олсон тус нэвтрүүлэгт ахлах ангиа төгсч байгаа

болон багш болох чин хүсэл, эрмэлзлэлтэй, авьяас сонирхолтой 120 гаруй хүүхэд оролцжээ. Тэднээс 90 гаруй нь ахлах ангийн сурагч байв.

МУБИС-ийн Хөтөлбөрийн нэгдсэн албаны оюутан хариуцсан мэргэжилтэн Т.Ариунжин “Эрдэмтэн багш нарын баг ажиллаж “Радио конкурс” уралдаант нэвтрүүлгийн асуулт, даалгаврыг боловсруулсан. Нэвтрүүлгийн эхний 10 минутад асуултаа задалж, сүүлчийн 10 минутад албан ёсны хуудсаараа дамжуулан хариултаа авч, зөв хариулт, хүүхдүүдээс гарсан санал хүсэлтийг тухай бүрт нь бүртгэлжүүлж ажилласан. Мөн МУБИС 2018-2019 оны хичээлийн жилд ямар хөтөлбөрөөр хичээллэж, ямар мэргэжлээр элсэлт авах вэ гэдэг мэдээллийг байнга өгч байсан. Үүнээс гадна Монгол Улсын Засгийн газрын 70, 100 хувийн тэтгэлэгт хөтөлбөрийг хэрхэн авах вэ, МУБИС-ийн захиарын 50 хувийн тэтгэлэгт хөтөлбөр, эрэгтэй оюутны 50 хувийн тэтгэлэгт хөтөлбөрт яаж хамрагдах вэ. Цаашилбал, кредитийн олон хөтөлбөр бий. Үүнд хэрхэн хамрагдах боломжтой вэ гэдэг мэдээллийг өгсөн. Мөн ахмад багш нарын зөвлөгөөг ч сурагчиддаа хүргэж амжлаа” гэв.

Оддын Цаг

Кендалл Женнер:

Би азтай, надаг зөвлөгөөг 12 хүн бий

Орчуулсан: Б.СУМБЯА

Загварын ертөнцөд од болон гялалзаж буй реалити шоуны од Кендалл Женнерын ярилцлагыг энэ Зудаагийн “Оддын цаг” буландаа орчуулан хүргэж байна. Тэрбээр 11 наснаасаа хойш олны нүдэн дээр буюу “Кардашианыхан” гэх реалити шоуны туршид өсч хүмүүжсэн байдаг. Мөн 14 настайгаасаа загварын ертөнцөд хөл тавьсан бөгөөд эдүгээ хамгийн үнэтэй загвар өмсөгчдийн тэргүүн эгнээнд бичигддэг юм.

-Кендалл сэргэлэн бүсгүй шиг харагддаг. Маш олон ажлыг зэрэг амжуулах юм. Энэ их эрч хүч хаанаас гараад байна аа?

-Би найз нөхдийнхөө хүрээлэл дунд байх дуртай. Тэд л намайг ухаалаг шийдвэр гаргахад нөлөөлдөг гэж боддог. Алхам тутамдаа адал явдалтай учирч байдаг учраас чөлөөт цаг гармагц өөрийгөө амраахыг хичээнэ. Аливаа зүйлийн тэнцвэрийг хадгалах нь чухал учраас гэр. Бас хөгжилтэй үйл ажиллагаа, адал явдалд хэчнээн завгүй байсан ч, цаг гаргадаг. Учир нь би тэдгээрээс эрч хүч авдаг юм. Хамгийн чухал нь эрүүл мэнд, галбир учраас аливаа зүйлийн тэнцвэрийг хадгалах хамгийн чухал. Товчхондоо, аливаа зүйлийг би өөрийнхөө төлөө хийдэг юм.

-Аль нэг томоохон загварын шоунд оролцохын өмнө сандардаг уу?

Ямар нэг зүйл хийх ёстой байтал цаг давчуу байх үед их сандардаг. Өнөөдөр гэхэд Каннд тайзан дээр гарахаас таван минутын өмнө сандарсан. Заримдаа хэт сандарснаас болоод бие хөшчихсөн мэт мэдрэмж төрөх нь бий. Та нарт ч гэсэн ийм мэдрэмж төрдөг байх. Ийм үед юу ч хийхгүй байх нь дээр байдаг юм. Сайхан даашинз, элдэв загварын хувцас өмсөх надад хөгжилтэй санагддаг. Зураг

авалтад зориулж миний үсийг янзалж, нүүрийг тод будна. Би чинь тайзны ард “За, миний үсийг ингээд янзлаад өгөөч”, “Миний нүүрийг будаарай” гээд л байж байдаг юм.

-Амьдрал танд утгагүй мэт санагдах үед хэн нэгний өгсөн хамгийн сайн зөвлөгөө юу вэ?

-Би их азтай. Надад зөвлөгөө өгөх 12 хүн байдаг. Миний эгч нар, ээж, бас эмээ гээд.

-Каннын кинонуудаас хэзээ ч үзсэн үйддаггүй киногоо нэрлээч гэвэл?

-Миний хамгийн дуртай кино бол “Moulin Rouge”. Би энэ киноны аль ч эшлэлийг нь цээжээр уншиж чадна.

-Өөрөө ер нь жүжигчин болохыг хүсдэг үү?

-Одоогийн амьдралдаа би сэтгэл хангалуун байдаг. Гэхдээ жүжигчин болохгүй гэж хэлж чадахгүй. Надад нас байна. Цаашид урт удаан замыг туулах учир юу ч хийж болно.

-Аль нэг ТВ шоуны тухай кино хийе гэж бодвол чи алийг нь сонгох вэ?

-“ Empire”. Гэхдээ намайг сонгох эсэхийг мэдэхгүй.

-Та дууддаг уу?

-Үгүй ээ. Би хөгжмийн чиглэлийн кинонд тоглоно гэж бодохгүй байна. “ Empire” шоунд маш их дуртай. Яагаад ч юм зүгээр л сайхан санагддаг юм.

-Кайли сүүлийн үед

шивээс хийлгэх дуртай болсон гэсэн. Бас таныг ямар нэг шивээс хийлгэхийг ятгах болсон гэсэн үү?

-Бихоёршивээстэй. Гэхдээ Кайлигийнхаас өөр. Минийх цагаан. Мэдээж Кайли надаас илүү олон шивээстэй.

-Магнумын зайрмагийг сурталчилж байсан. Магадгүй энэ таны амьдралд байдаг л зүйл байх. Гэхдээ хэвийн жингээ хэрхэн барьдаг вэ?

-Ажиллаж байхдаа би бусдын л адил хооллодог. Би төгс хооллодог гэж хэлэхийг хүсэхгүй байна. Зарим үед дэглэм барихыг хичээдэг. Харин зарим үед Кендалл таван таваг паста, гурван ширхэг зайрмаг идчихдэг л юм даа. Маш цөөн удаа.

-Өөрөө нүүрээ будах үедээ ихэвчлэн яадаг вэ?

-Нүдээ хэт тод өнгөөр будах дургүй. Харин байгалиас өөрт өгөгдсөн гоо үзэсгэлэнгээ илүү тодотгохыг хүсдэг. Одоо надад байгаа бүх зүйлсдээ би хайртай. Их биш ч, намайг сайхан харагдуулдаг ямар нэгэн зүйл байсаар л байгаа.

-Малиа Обама коллежид явахын өмнө цагийн ажил хийхээр шийдсэнээ зарлаж байсан. Нэр алдартай гэр бүлийнхний хувьд та юу хийх төлөвлөгөөтэй байна даа?

-Би магадгүй Нью-Йорк руу нүүж, тэндээ шинэхэн амьдралын хэв маягтай болох байх.

-Өөрийн чинь инстаграмм дахь зураг 2016 оны хамгийн их лайктай зургаар тодорсон. Энэ талаар юу хэлэх вэ?

-Миний зураг олон хүнд таалагдсан нь үнэхээр гайхалтай. Тэр зургийг тийм олон лайк авна гэж төсөөлөөгүй. Нэг удаа зүгээр л шалан дээр хэвтэж байхдаа л санамсаргүй тэр зургийг авсан юм. Бараг нэг жилийн өмнө Монакод байхдаа. Сайхан, гайхалтай л гэж бодож байна. Гэхдээ үүнээс болж, миний амьдралд өөрчлөгдсөн зүйл байхгүй.

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр 26
Шөнө 15

Нөгөөдөр
Өдөр 27
Шөнө 11

Өдрийн зурхай

ЗУНЫ ТЭРГҮҮН
ХӨХӨГЧИН МОГОЙ
САРЫН ЕСӨН УЛААН
МЭНГЭТЭЙ ЦАГААГЧИН
ХОНЬ ӨДӨР

Үс засуулбал: Сайн
нохортэй нохорлоно
Наран ургах, шингэх:
05.02-19.49



Тухайн өдөр гахай, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хяналгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр гэгтнийг шийтгэх, хишиг даллага дуудуулах, насан бүтээл хийлгэх, мал худалдан авах, мал түгээх, сахил санваар авах, хануур, төөнүүр хийлгэх, хийлгөрийн дарцаг хатаахад сайн. Эрдэнийг гадагш өгөх, уул овоо тахихад муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод ураги төрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал “Сайн нохортэй учирах” хэлтэх сайн.

Бидэнд тохиолдсон



хүндхэн хөгтэй
явдлууд

Энхтөмөр
Нандинчимэг



Би чих ухаа хоббитой юм аа. Над шиг хүн зөндөө биз дээ. Нэг удаа томилолтоор явж байгаад ажлынхаа ахыг чихээ ухуулчих гэвэв гуйв. Тэгсэн ах харин “Тэгэж чамайг баярлуулахгүй шүү. Харьж эхнэрээ баярлуулна” гэдэг юм даа. Эхнэр нь бас чих ухаа бөөн дур гэсэн. кккк

СОНИРХУУЛАХАД

Мисс А.Баярцэцэг Холливудын кинонд дүр бүтээнэ

Эх орноо төлөөлж “Дэлхийн мисс”-ийн тэмцээнд оролцож 11-т шалгарч чадсан бүсгүй бол мисс А.Баярцэцэг билээ. Түүнийг “Дэлхийн мисс”-ийн тэмцээнд оролцож байх үеэр Диснейн Сан Франциско дахь агентлагаас “Мулан” уран сайхны кинонд шалгуулах урилга ирүүлж байсан билээ. Том агентлагийн хараанд өртөж, шалгаруулалтад оролцох урилга авна гэдэг бол ховор завшаан. Тиймээс мисс А.Баярцэцэг тэмцээнээ дуусаад тэдний урилгын дагуу ярилцлагад оржээ. Гэвч олон шалгуурын дараа гол дүрийн жүжигчинг сонгох учраас цаг хугацаа шаардлагатай байдаг гэнэ. Тэгвэл мисс А.Баярцэцэг маань Холливудын алдарт жүжигчин Стивен Сигалын кинонд тоглохоор болжээ. Тэрбээр өөрийн цахим хуудасдаа “Нэг хаалга хаагдахад нөгөө хаалга нээгдэж байдаг гэдэг. Дэлхийн миссийн тэмцээнд орсноороо энэ сайхан хүмүүстэй танилцах боломж олдсон билээ. Өнгөрсөн хоёрдугаар сард Тайланд улсад болсон киноны шалгаруулалтын хариу маань иржээ. Ирэх жил дэлгэцнээ гарах “Attrition” киноны томоохон туслах дүр болох Куга-н дүрд тоглохоор боллоо” гэсэн байна. Кино зураг авалт ирэх долоодугаар сард Тайланд улсад эхлэх аж.



ДУУЛГАХ СОНИН

Үндэсний телевизийн шинэчлэлд иргэд сэтгэл хангалуун байна

Монголын үндэсний олон нийтийн телевиз нэг намын мэдэлд орсон, эрх баригч нам хэн байхаас шалтгаалж тэдэнд үйлчилдэг гэх мэт сөрөг шүүмжлэл нийгэмд хүчээ авч байсан билээ. Тэр ч байтугай УИХ-ын даргаар З.Энхболд ажиллаж байхдаа үндэсний телевизэд баахан архичид цуглачихсан, ажил хийдэг хүн байхгүй гэсэн утгатай зүйл ярьж, МҮОНТ-ийн ажилчид З.Энхболдыг уучлалтгүйхыг шаардаж байсан удаатай. Тэгвэл сүүлийн үед МҮОНТ-ийн удирдлага шинэчлэгдэж, улмаар шуурхай, шинэлэг байх чиглэлд олон ажил хийж буй нь иргэдийн талархлыг хүлээж эхлээд байна. Нэг намын хэвлэлийн алба шиг, эс бөгөөс албан мэдээгээр дүүрчихээд байсан гэх шүүмжлэл ард хоцорч, Үндэсний телевиз 21 аймаг, гадаадын олон орноос мэдээ мэдээллийг шуурхай дамжуулах сэтгүүлчдийн сүлжээтэй болсон нь саяхан билээ.

Өөрөөр хэлбэл, сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд Олон нийтийн телевиз анх удаа гадаадын 10 гаруй орноос мэдээ мэдээллийг өөрийн сэтгүүлчдээрээ дамжуулан шуурхай мэдээлж байсан тохиолдол байхгүй аж. Телевизийн түүхэнд нэгэн шинэ хуудас нээж буй энэхүү шинэчлэлд иргэд тун ч ам сайтай байгаа юм. Бидний аав ээжийн, эмээ өвөөгийн үеэс үздэг байсан “Цагийн хүрд” илүү шинэ дүр төрхтэйгээр эргэн ирж, мэдээ мэдээллийг цаг тутамд хамгийн шуурхай хүргэж эхэлжээ. Энэхүү ажлыг хийж буй МҮОНТ-ийн баг хамт олонд уншигчдынхаа өмнөөс ажлын амжилт хүсье.

УЛАМЖЛААТ АНАГААХ УХААНЫ "ГАНЗҮҮ" ЭМНЭЛЭГ

Манай эмнэлэг дотор 5 цув, 6 сав эрхтэний өвчлөлийг уламжлалт анагаах ухааны таван заслын аргаар эмчилж, 80-аас дээш хувьтай үр дүн үзүүлдэг.

Бид танад:

- Ган болон мөнгөн зүү, шалнагаан зүү

-Хануур, сам соруул

-Шарлаа

-Бумба төөнө засал

-Халуун чулуу, давсан халуун жин засал

-Эмчилгээний цэгэн барил

-Архи, сүү, сүүлэн тостой бүтэн биеийн барил зэрэг уламжлалт анагаах ухааны эмчилгээ үйлчилгээ, мэдрэл, харшил, хүүхэд, эмэгтэйчүүдийн оношлогоо эмчилгээг цогцоор нь хийж үйлчилнэ.



ЭРҮҮЛ МЭНДИЙН
ЧАНАРТАЙ ТУСЛАМЖ
ҮЙЛЧИЛГЭЭГ БИД ҮЗҮҮЛНЭ
Холбогдох утас: 9999-5584
9900-2332



Салбар 1 хаяг: Найрсаг
Улаанбаатар их
дэлгүүрийн баруун талд
"Ганзүү" эмнэлэг
/Өдрийн эмчилгээ/



Салбар 2 хаяг: III
хороолол, 28
дугаар сургуулийн
баруун талд
"Ганзүү" эмнэлэг
/Хэвтүүлэн
эмчилнэ/